

**ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН
ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ**



Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн
хуралдааны 2025 оны 10 дугаар сарын 31-ний
өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 1/1636 дугаар албан бичгээр ирүүлсэн Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хэлэлцлээ.

Танай яамнаас өмнө 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 1/1169 дугаар албан бичгээр ирүүлсэн Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2025 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/1311 дугаар албан бичгээр санал өгсөн бөгөөд эдгээр хоёр төслийг харьцуулан, нэмэлт өөрчлөлт оруулсан зохицуулалтын хэмжээнд дараах саналыг хүргүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно. Үүнд:

1."бүтэн өнчин хүүхэд"-ийн талаар төсөлд тусгасан нэр томъёоны тайлбарыг зөв, үндэслэл бүхий тодорхойлох шаардлагатай талаарх өмнөх саналаа дахин илэрхийлж байна. Тухайн хүүхэд Гэр бүлийн тухай хуульд заасан "бүтэн өнчин хүүхэд"-д гэдэгт хамаарахыг шүүх тогтоох эсэх, тогтоох бол урьдчилсан нөхцөл, үндэслэл, үүсэх үр дагаврыг хэрхэн шийдвэрлэх зэргийг тухайлан хуульчлах нь хүүхдийн эрхийг хамгаалахад ач холбогдолтой юм.

2."гэр бүлийн гишүүн" гэдэгт гэрлэгчид, гэрлэгчдийн хамтран амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхдийн талаар заасан боловч үүнд Донорын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасан аргаар төрсөн хүүхэд хамаарах эсэх нь тодорхойгүй үлдсэн байгааг нэмж оруулах.

Түүнчлэн, төслийн 15 дугаар зүйлээр "Гэрлэлт цуцлахад шүүх гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийг тодорхойлох"-оор байгаа хэдий ч уг зүйл гэрлэгчдээс бусад гишүүдэд хамаарах эсэх нь ойлгомжгүй байна. Хуульд "гэр бүлийн гишүүн"- тэй холбоотой зохицуулалтыг оруулахдаа "гэрлэгчид", "гэрлэгчдийн хүүхэд", "гэрлэгчдийн хамт амьдарч байгаа төрөл, садангийн хүн"-д хамаарах тохиолдлыг зааглан, тодорхой, ойлгомжтой, бусад хуультай уялдуулан тусгах нь эдгээр этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлох, асрамжийн болон бусад асуудлыг шийдвэрлэхэд чухал юм. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Гэр бүлийн тухай хуулийг боловсронгуй болгох үзэл баримтлалд нийцүүлэн өмнөх саналаа мөн дэмжиж байна.

3.Хуулийн үзэл баримтлалаас үзвэл Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-иар нөхөн үржихүйн тусгай аргыг хэрэглэж "хүүхэд төрүүлэх" асуудлыг зохицуулахааргүй байна. Донорын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дах хэсэгт зааснаар эрүүл мэндийн шалтгаанаар өөрөө жирэмслэх, ураг



тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон эмэгтэйг тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болох боломжтой тул төслийн 27.1 дэх хэсгийг уг аргаар төрүүлсэн хүүхдийн "эцэг, эхийг тогтоох" агуулгаар найруулах шаардлагатай.

Түүнчлэн, "...төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд..."-ийн эрх, тэтгэвэр тогтоох, үрчлүүлэх, үрчлэн авах, гэр бүлийн гишүүнд хамаарах эсэх зэрэг зохицуулалтад Донорын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасан аргаар төрсөн хүүхэд хамаарах эсэхийг тусгах нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь хэсгийн "...тодорхой, ойлгомжтой байх..." шаардлагад нийцэх юм.

Мөн Донорын тухай хуульд заасны дагуу хүүхэдтэй болсон, гэрлээгүй эмэгтэйн хүүхдийн эцэг, эхийг тогтоох, асуудлыг хэрхэн зохицуулахыг тодорхой, нэг мөр болгох нь ач холбогдолтой юм. Тухайлбал, төслийн 24.6, 27.3, 27.5-т "гэрлэгчид" гэж, 27.4-т "...эхнэр эсхүл нөхөр..." гэж заажээ.

Төслийн 4.1.14-т "...нөхөн үржихүйн туслах технологийг ашиглаж хүүхэдтэй болох..." гэснийг тайлбарласан боловч 24.7-д "технологи", 27-д "арга" гэсэн нэр томъёо хэрэглэсэн нь ойлгомжгүй байдал үүсгэхээр байгааг, 27.2 дахь хэсэгт Донорын тухай хуулийн 18.7 дахь хэсгийг үндэслэл болгосон боловч уг зүйлд "... өөр хүний бэлгийн эсийг ашиглах..." тухай бус, харин "гэрээний загварыг батлах" эрх бүхий этгээдийг тодорхойлсон, зохицуулалт байгааг анхаарах.

Дээр дурдсантай холбогдуулан, нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж хүүхэд төрүүлэх асуудлаар Улсын дээд шүүхээс өмнө өгсөн "...шинэ зохицуулалтын хувьд зорилго, мөн чанарыг тодорхой илэрхийлэхийн тулд Донорын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасан хэм хэмжээтэй уялдуулан зохицуулах... нөхөн үржихүйн аргыг хэрэглэх нь тодорхой үндэслэлтэй байх... хуулиар хязгаарлагдах... сөрөг үр дагавраас сэргийлэх..." саналаа дахин гаргаж байна.

4.Эрх зүйн харилцаа "дуусгавар болсонд тооцогдох", "дуусгавар болох" нь хоорондоо ялгаатай ойлголт тул одоо хүчин төгөлдөр байгаа Гэр бүлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсгийн зохицуулалтыг төсөл боловсруулахдаа анхаарах. Төслийн 65.7, 69.7 дахь хэсгийг хооронд уялдуулах, Иргэний хуулийн 24.3 дахь хэсгийн зохицуулалтад төслийн 10.1.1 дэх хэсгийг нийцүүлэн найруулах шаардлагатай байна.

5.Хүүхдийн асрамжийн талаарх 13.8 дахь хэсэгт "...талууд өөрөөр тохиролцоогүй бол..." гэж нэмснийг хасаж өмнөх төсөлд тусгасан байдлаар үлдээх эсхүл "тохиролцсон байдлыг асрамж тогтоохдоо харгалзан үзэх" агуулгаар оруулах нь ач холбогдолтой юм.

Гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж тогтоолгох, тэтгэлэг гаргуулах асуудлыг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь Иргэний хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2,-т зааснаар иргэний эрх зүйн харилцааг үүсгэх үндэслэл болдог тул эдгээр асуудлаар зохигчид эвлэрэн хэлэлцэж тохиролцсон, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хэргийг хялбаршуулсан журмаар хянан хэлэлцэж болохгүй. /УДШ-ийн 2018-11-25-ны өдрийн 46 дугаар тогтоолын 9.3.3, 9.3.4/



6.Гэрлэлт цуцлахад хүүхдэд тэтгэлэг тогтоох, хүүхдийн асрамж болон бусад асуудлыг хуульд нарийвчлан тусгах хэрэгцээ шаардлага байгаагаас гадна гэрлэлт цуцлах хүртэл хугацаанд хүүхдэд тэтгэлэг тогтоох, асрамжийн асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага практик дээр үүсдэг. Хуулийн төсөлд хүүхдийн асрамж тогтоох, асрамж тогтоосны дараа үүсэх магадлалтай маргаатай асуудлыг нэг мөр шийдвэрлэх, хүүхдэд зориулсан нэмэлт зардал зэргийг тодорхой зохицуулах шаардлагын талаарх өмнөх саналаа дэмжиж байна.

7.Төслийн 5.3, 14.1.2, 25.1 дэх хэсгийг хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн өмнө төсөлд тусгасан байдлаар үлдээх, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах 13.12,13.13-т байгаа заалтыг энэ төсөлд бус, харин Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд тусгахаар байна.

8.Гэрлэлт цуцалснаас гэр бүлийн гишүүнд оногдох дундын эд хөрөнгийн маргааныг шүүх шийдвэрлэх, ногдох хэсгийг хэрхэн тодорхойлох зэрэг асуудлыг Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-иар тухайлан, нэг мөр зохицуулахаар оруулах шаардлагатай.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААН